

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДСЭН СУРГАЛТЫН ЯВАГДЛАА.

2025.03.27

Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн үзэл баримтлал, суралцагчийн эзэмших суурь чадамж, суралцахуйн онол, арга зүйг таниулах, XXI зууны багш, удирдах ажилтанд шаардагдах мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, сургалтын байгууллагын менежментийг сайжруулах, манлайлах ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой хүүхдийн цэцэрлэгт ажиллаж буй багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт 2025 оны 03 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгт зохион байгуулагдлаа.

Сургалтад эрхлэгч болон эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч 4, арга зүйч 4, багш 27 нийт 35 хүн 100 хувийн ирцтэйгээр оролцлоо. Сургагч багшаар Нийслэлийн 62 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б.Даваасамбуу ажиллав.

Сургалтын эхний өдөр

Үндсэн сургалтын удирдамж, зохион байгуулалтын талаар мэдээлэл хийж, эргэцүүллийн 4 загвар түүний ач холбогдол, үйл ажиллагаанд хэрхэн хэрэглэх талаар танилцуулж, багаар ажиллан хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Үдийн дараа мозаик болон мэдлэ платформыг сургалт, үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах талаар хүн бүр дадлага ажил хийж цахим орчинд ажиллах ур чадвараа нэмэгдүүлэв. Сургалтад оролцсон багш, удирдах ажилтан 35 хүнээс 8 хүний мэдлэ болон тоес хаягыг оруулсан байна.

Сургалтын хоёр дахь өдөр

2025-2026 оны хичээлийн жилээс хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн танилцуулга, онцлог хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй болох “Сонирхон судлахад суурилсан суралцахуй”, “Тоглоомд суурилсан суралцахуй”, “Зохиолд суурилсан суралцахуй”, “Төсөлд суурилсан арга зүй”-тэй танилцаж, дээрх арга зүйг хэрэгжүүлдэг цэцэрлэгүүд өөрсдийн туршлагаа хуваалцав.

Сургалтын төгсгөлд үндэсний соёлын боловсролыг сургуулийн өмнөх боловсролд олгох модуль хөтөлбөрийн талаар танилцуулга хийгдсэн болно.

Сургалтаар багш, удирдах ажилтан

-Ирэх хичээлийн жилийн хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийн онцлог, хөтөлбөрийг хэрэгжүүлэх шинэлэг 4 арга зүйтэй танилцсан.

-Эргэцүүллийн 4 арга, онолтой танилцаж дадлага хийсэн.

-Мэдлэ болон багш платформыг ажиглаж мэдээлэл авах боловсруулах, сургалтын төлөвлөлт, хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүйд суралцсан.

ТАЙЛАН БИЧСЭН: СӨБ ХАРИУЦСАН АРГА ЗҮЙЧ

Д.ӨНӨРЦЭЦЭГ

ХАВСРАЛТ

